



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Шарга сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/19/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Алтай хот

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413

Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055

Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах Аудитор Д.Цэрэнханд

Утас: 99147999

Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Запруулсан алдаа	15
4.2 Төлбөрийн акт.....	16
4.3 Албан шаардлага	16
4.4 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ШАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Р.ОЮУНЧИМЭГ ТАНАА

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022. 02. 25 № 114
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Шарга сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Шарга сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Хандивын орлогыг данс бүртгэлд тусгаагүй зарцуулсан, зөвшөөрөлгүй нэмэлт дансаар хандив авч зарцуулсан, шатахууны норм хэтрүүлэн зарцуулсан, нийгмийн даатгалын тайлан, татварын тайлан зөрүүтэй, өглөг авлагыг үнэн зөв тусгаагүй, тооцоо нийлээгүй, төсвийн хэмнэлтийн горим зөрчин тавилга, эд хогшил бэлтгэсэн, ЗДНХ-өөс зориулалт бусаар зарцуулсан, бараа материалын тооллого хийгээгүй, үндсэн хөрөнгийн тооллого зөрүүтэй хийсэн, өмнөх шийдвэрийг хэрэгжүүлээгүй зэрэг нийт 68.3 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аймгийн Засаг даргын захирамж,

07922347

АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	81,189,877.00	86,461,133.00
35	БАРАА МАТЕРИАЛ	81,189,877.00	86,461,133.00
35100	Түүхий эд материал	4,465,977.00	4,465,977.00
35110	Тусгай зориулалттай материал	4,465,977.00	4,465,977.00
35400	Хангамжийн материал	7,662,800.00	8,434,056.00
35410	Бичиг хэргийн материал	568,800.00	19,500.00
35420	Аж ахуйн материал	5,000,000.00	8,414,556.00
35600	Мал амьтад	69,061,100.00	73,561,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	923,560,669.37	1,001,089,694.99
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	923,560,669.37	1,001,089,694.99
39200	Биет хөрөнгө	921,222,669.37	998,751,694.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	575,704,298.07	592,391,598.07
39202	Хуримтлагдсан элэгдэл	-111,349,527.05	-133,580,220.94
39203	Авто-тээврийн хэрэгсэл	233,554,372.00	243,580,372.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-154,850,494.10	-163,041,627.42
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	154,133,040.50	161,455,759.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-109,104,444.40	-108,951,898.61
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,720,754.27	19,346,371.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,882,107.08	-9,709,652.96
39209	Зам, гүүрийн байгууламж	87,399,696.00	87,399,696.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-7,283,307.98	-14,006,361.50
39214	Бусад үндсэн хөрөнгө	373,276,749.00	483,039,649.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-124,096,359.86	-159,171,988.65
39300	Биет бус хөрөнгө	2,338,000.00	2,338,000.00
39301	Программ хангамж	2,230,000.00	2,230,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,230,000.00	-2,230,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,338,000.00	2,338,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,004,750,546.37	1,087,550,827.99
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,000,629,236.37	1,087,550,827.99
51	Засгийн газрын хувь оролцоо	1,000,629,236.37	1,087,550,827.99
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	274,846,668.74	274,846,668.74
51200	Хуримтлагдсан үр дүн	675,848,002.70	762,769,594.32
51210	Өмнөх үеийн үр дүн	644,541,228.00	675,848,002.70
51220	Тайлант үеийн үр дүн	31,306,774.70	86,921,591.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	49,934,564.93	49,934,564.93
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,004,750,546.37	1,087,550,827.99

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	483,944,152.00	581,205,976.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	153,635,389.00	133,447,356.00
120	Нийтлэг татварын бус орлого	153,635,389.00	133,447,356.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	153,635,389.00	109,647,556.00

**Говь-Алтай аймгийн Шарга сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	577,300.00	677,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	153,058,089.00	108,970,556.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	3,839,800.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	19,960,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	330,308,763.00	447,758,620.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,314,563.00	86,079,220.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	9,800,000.00	33,450,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,089,563.00	51,849,220.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	425,000.00	780,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	306,994,200.00	361,679,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	306,994,200.00	361,679,400.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	452,637,377.30	494,284,384.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	452,637,377.30	494,284,384.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	439,330,266.30	480,704,532.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	214,352,743.00	224,451,172.34
210101	Үндсэн цалин	139,251,289.53	142,536,025.34
210102	Нэмэгдэл	45,299,999.79	45,600,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	6,600,000.00
210104	Урамшуулал	11,501,454.00	4,995,690.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,299,999.68	24,719,457.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,754,448.00	26,925,324.08
210201	Тэтгэврийн даатгал	26,035,548.00	18,294,846.00
210202	Тэтгэмжийн даатгал	500,000.00	2,177,199.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	400,000.00	1,741,759.21
210204	Ажилгүйдлийн даатгал	300,000.00	428,319.12
210205	Эрүүл мэндийн даатгал	518,900.00	4,283,200.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,457,300.00	16,019,679.00
210301	Гэрэл, цахилгаан	2,500,000.00	2,844,179.00
210302	Түлш, халаалт	13,917,300.00	12,283,000.00
210303	Цэвэр, бохир ус	40,000.00	892,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,287,384.00	26,336,650.00
210401	Бичиг хэрэг	3,419,764.00	3,195,020.00
210402	Тээвэр, шатахуун	17,168,950.00	20,488,330.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,497,520.00	1,305,400.00
210404	Ном, хэвлэл	75,000.00	63,500.00

**Говь-Алтай аймгийн Шарга сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	112,000.00	207,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,014,150.00	777,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	300,400.00
2105	Нормативт зардал	876,000.00	757,200.00
210502	Хоол, хүнс	598,000.00	207,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	278,000.00	550,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	120,000.00	9,936,069.00
210602	Тавилга	0.00	103,369.00
210604	Урсгал засвар	0.00	9,832,700.00
2107	Томилолт, зочны зардал	3,102,000.00	2,130,400.00
210702	Дотоод албан томилолт	3,102,000.00	2,130,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,463,537.00	22,594,814.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,977,239.00	21,969,550.00
210803	Даатгалын үйлчилгээ	351,950.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	133,638.00	45,188.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	295,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	24,710.00	18,076.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	138,916,854.30	151,553,224.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,626,657.00	55,892,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	245,000.00	100,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	107,045,197.30	95,561,174.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,307,111.00	13,579,851.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,399,500.00	9,939,559.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,399,500.00	9,939,559.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,907,611.00	3,640,292.58
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,907,611.00	3,640,292.58
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	31,306,774.70	86,921,591.62
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	31,306,774.70	86,921,591.62

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	274,846,668.74	49,934,564.93	644,541,228.00	969,322,461.67

**Говь-Алтай аймгийн Шарга сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	274,846,668.74	49,934,564.93	644,541,228.00	969,322,461.67
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	31,306,774.70	31,306,774.70
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	274,846,668.74	49,934,564.93	675,848,002.70	1,000,629,236.37
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	274,846,668.74	49,934,564.93	675,848,002.70	1,000,629,236.37
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	274,846,668.74	49,934,564.93	675,848,002.70	1,000,629,236.37
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	86,921,591.62	86,921,591.62
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	274,846,668.74	49,934,564.93	762,769,594.32	1,087,550,827.99

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	330,886,063.00	448,435,620.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	577,300.00	677,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	577,300.00	677,000.00

**Говь-Алтай аймгийн Шарга сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	577,300.00	677,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	577,300.00	677,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	330,308,763.00	447,758,620.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,314,563.00	86,079,220.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	9,800,000.00	33,450,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,089,563.00	51,849,220.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	425,000.00	780,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	306,994,200.00	361,679,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	306,994,200.00	361,679,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	320,716,063.00	404,325,620.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	320,716,063.00	404,325,620.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	307,408,952.00	386,745,768.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	210,231,433.00	228,128,832.34
210101	Үндсэн цалин	135,129,979.53	146,035,354.34
210102	Нэмэгдэл	45,299,999.79	45,600,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	6,600,000.00
210104	Урамшуулал	11,501,454.00	4,995,690.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,299,999.68	24,897,788.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,754,448.00	26,925,324.08
210201	Тэтгэврийн даатгал	26,035,548.00	18,294,846.00
210202	Тэтгэмжийн даатгал	500,000.00	2,177,199.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	400,000.00	1,741,759.21
210204	Ажилгүйдлийн даатгал	300,000.00	428,319.12
210205	Эрүүл мэндийн даатгал	518,900.00	4,283,200.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,156,500.00	13,925,679.00
210301	Гэрэл, цахилгаан	2,500,000.00	2,844,179.00
210302	Түлш, халаалт	15,616,500.00	10,189,000.00
210303	Цэвэр, бохир ус	40,000.00	892,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,242,984.00	24,859,150.00
210401	Бичиг хэрэг	3,888,064.00	2,693,720.00
210402	Тээвэр, шатахуун	17,168,950.00	19,628,530.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,497,520.00	1,305,400.00
210404	Ном, хэвлэл	90,000.00	63,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	198,800.00	188,000.00

**Говь-Алтай аймгийн Шарга сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	399,650.00	980,000.00
2105	Нормативт зардал	876,000.00	792,200.00
210502	Хоол, хүнс	598,000.00	207,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	278,000.00	585,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	120,000.00	9,672,519.00
210602	Тавилга	0.00	104,819.00
210604	Урсгал засвар	0.00	9,567,700.00
2107	Томилолт, зочны зардал	3,102,000.00	2,130,400.00
210702	Дотоод албан томилолт	3,102,000.00	2,130,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,606,037.00	21,726,864.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,119,739.00	21,101,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	351,950.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	133,638.00	45,188.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	295,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	24,710.00	18,076.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,319,550.00	57,585,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,074,550.00	57,485,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	245,000.00	100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,307,111.00	16,580,251.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,399,500.00	12,939,959.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,399,500.00	12,939,959.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,907,611.00	3,640,292.58
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,907,611.00	3,640,292.58
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	10,170,000.00	44,110,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	10,170,000.00	44,110,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,170,000.00	44,110,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,170,000.00	44,110,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,170,000.00	44,110,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-10,170,000.00	-44,110,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	361,979,400.00	358,716,107.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	361,979,400.00	358,716,107.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	359,479,400.00	355,216,548.42

**Говь-Алтай аймгийн Шарга сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	223,800,000.00	223,530,088.34
210101	Үндсэн цалин	146,300,000.00	146,035,354.34
210102	Нэмэгдэл	45,600,000.00	45,600,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,600,000.00	6,600,000.00
210104	Урамшуулал	5,000,000.00	4,995,690.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,300,000.00	20,299,044.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,164,400.00	26,833,187.08
210201	Тэтгэврийн даатгал	19,428,400.00	18,202,709.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,184,000.00	2,177,199.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,747,200.00	1,741,759.21
210204	Ажилгүйдлийн даатгал	436,800.00	428,319.12
210205	Эрүүл мэндийн даатгал	4,368,000.00	4,283,200.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,100,000.00	13,925,679.00
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	2,844,179.00
210302	Түлш, халаалт	10,200,000.00	10,189,000.00
210303	Цэвэр, бохир ус	900,000.00	892,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,041,500.00	18,955,530.00
210401	Бичиг хэрэг	2,200,000.00	2,191,620.00
210402	Тээвэр, шатахуун	14,300,000.00	14,293,010.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,300,000.00	1,299,400.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	63,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	188,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	941,500.00	920,000.00
2105	Нормативт зардал	1,100,000.00	792,200.00
210502	Хоол, хүнс	500,000.00	207,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	585,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,733,500.00	30,492,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,500,000.00	17,292,000.00
210602	Тавилга	6,733,500.00	6,733,000.00
210604	Урсгал засвар	6,500,000.00	6,467,700.00
2107	Томилолт, зочны зардал	2,300,000.00	2,130,400.00
210702	Дотоод албан томилолт	2,300,000.00	2,130,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,549,000.00	1,871,564.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,459,000.00	1,246,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	45,188.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	40,000.00	18,076.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,691,000.00	36,685,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,691,000.00	36,685,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,500,000.00	3,499,559.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,500,000.00	3,499,559.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	3,499,559.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	361,979,400.00	358,716,107.42
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	361,679,400.00	358,039,107.42
320001	Орон нутгийн төсвөөс	361,679,400.00	358,039,107.42
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	300,000.00	677,000.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	677,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	86,079,220.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	86,079,220.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	75,639,220.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,598,744.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,598,744.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,137.00
210201	Тэтгэврийн даатгал	92,137.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,903,620.00
210401	Бичиг хэрэг	502,100.00
210402	Тээвэр, шатахуун	5,335,520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	60,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,289,819.00
210602	Тавилга	189,819.00
210604	Урсгал засвар	3,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,854,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,854,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,900,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,800,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,440,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,440,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,440,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	86,079,220.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	86,079,220.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	33,450,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,849,220.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	780,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Шарга сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэнханд гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Шарга сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03/38 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэн ард иргэдийнхээ сайхны төлөө, тэдний амьдралын чанарыг байнга дээшлүүлэхэд боломжоороо хангаж сумынхаа тохижилт, соёлжилтыг сайжруулахад чиглэнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Шарга сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 452.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 7.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд 2021 оны нийт зардал 493.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 7.9 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Шарга сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7 хувиар буюу 79.6 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 86.4 сая төгрөг болж 5.2 сая төгрөгөөр өссөн нь худалдан авсан бараа материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 68.3 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 3.6 сая төгрөгийн бараа материал авч, үйл ажиллагаандаа 65.9 сая төгрөгийн материалыг зарцуулж, 0.7 сая төгрөгийн актлан данснаас хассан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,591.7 сая төгрөг болж 141.3 сая төгрөгөөр өссөн нь хандиваар 128.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй ирсэнтэй холбоотой. Төсвийн хөрөнгөөр 44.1 сая төгрөгийн, хандиваар 128.9 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж авч, 25.6 сая төгрөгийн хөрөнгө акталж устган данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,084.4 сая төгрөг болж 84.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 16 хувиар буюу 97.2 сая төгрөгөөр өссөн нь цар тахалтай холбоотойгоор үнэ төлбөргүй бараа материал, хөрөнгө ирсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 762.7 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 370.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 7.7 сая төгрөгөөр бууруулж, 362.9 сая төгрөгөөр баталжээ.



3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 361.6, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 0.3 сая төгрөг нийт 362.9 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 361.6 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 0.7 сая төгрөг нийт 362.3 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 358.7 сая төгрөгийг зарцуулж, 3.6 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 358.7 сая төгрөг буюу 99 хувьтай байгаа цалин хөлсний зардлыг 0.3 сая төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ыг 1.3 сая төгрөгөөр, цалингийн зардлыг 0.3 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 0.3 сая төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг бусдаар гүйцэтгүүлэх бараа үйлчилгээний зардлыг 0.7 сая төгрөгөөр, дотоод албан томилолтын зардлыг 0.2 сая төгрөгөөр, нормативт зардлыг 0.3 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 0.5 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн дээд шатны төсөв захирагчаас 51.8 сая төгрөг, Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив 33.4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 0.78 сая төгрөг нийт 86.0 сая төгрөгийн орлогыг үйл ажиллагаандаа бүрэн зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 200.9 сая төгрөгийн орлогын 43 гүйлгээнээс 170.7 сая төгрөгийн 9 гүйлгээг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 4.9 сая төгрөгийн худалдан авалтын гүйлгээг шивүүлээгүй

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Татварын ерөнхий хуулийн 28.2, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалтуудтай заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 29.7 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн ба албан шаардлагын хэрэгжилтийг хангуулаагүй байна. Иймд өмнөх шийдвэр хэрэгжүүлж ажиллаагүй тул сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээ.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн хэмнэлтийн горим, бараа материалын тайлангийн тулгалт, жилийн эцсийн тооллого, шатахууны зардлын зарцуулалт, хандив тусламжийн орлого, түүний зарцуулалтыг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 219.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9.9 сая төгрөгийн алдааг залруулан, 0.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 209.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

- Нэмэлт санхүүжилтээс малжуулсан 4.0 сая төгрөгийн малыг данс бүртгэлд тусгаагүй, шууд зардлаар тайлагнасан
- ЗДНХ-өөс олгосон 1.7 сая төгрөгийн нүүрсний хөнгөлөлтийг шууд зардлаар тайлагнасан
- Бараа материалын тайланд үнэ төлбөргүй авсан хөрөнгө 1.7 сая төгрөгийг төсвийн хөрөнгөөр худалдан авснаар тайлагнасан
- Жилийн эцэст шатахууны нярвын тайлан үлдэгдэлгүй байхад, НББ-ээр 0.85 сая төгрөгийн үлдэгдэлтэй
- Үр дүнгийн тайланд акталж устгасан бараа материал 0.7 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд тайлагнасан.
- Мөнгөн гүйлгээний тайланд 1.0 сая төгрөгийн бараа үйлчилгээний бусад зардлыг нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардалд тайлагнасан



4.2 Төлбөрийн акт

Хандиваар өгсөн 100л шатахуун 0.17 сая төгрөг, бэлэн мөнгө 0.2 сая төгрөгийг данс бүртгэлд тусгаагүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 25.7-т "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана." гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул төлбөрийн акт хүргүүлээ.

Шатахууны зардлаас 0.25 сая төгрөгийг норм хэтрүүлэн зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна." Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул төлбөрийн акт хүргүүлээ.

4.3 Албан шаардлага

Засаг даргын нөөц хөрөнгөнөөс шашны үйл ажиллагаанд 1.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын .. "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 7.9 сая төгрөгийн илүү, 8.2 сая төгрөгийн дутуу төлөлттэй боловч санхүүгийн тайланд тусгаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүлээ

Тайлант онд 4.9 сая төгрөгийн худалдан авалтын гүйлгээг шивүүлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүлээ

Нэмэлт санхүүжилтийн дансаар 20.2 сая төгрөгийн хандив авч, зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 44.1-т "Төсвийн байгууллага дараах шаардлагыг хангасан тохиолдолд туслах үйл ажиллагаа явуулж, орлого олж болно." гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүлээ.

Төрөөс хариуцах цэвэр усны төлбөрт 3.4 сая төгрөгийг анхан шатны баримтгүйгээр нэхэмжлэн авч зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын 5-т "Төрийн байгууллагын цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус, хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг төлөвлөсөн хэмжээнээс бууруулахгүй, өөр зардалд шилжүүлэхгүйгээр цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур, ус хангамж, ариутгах татуурга, хог хаягдлын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагад шууд шилжүүлж байхыг төсвийн бүх шатны захирагч нарт даалгасугай" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүлээ.

Нийгмийн даатгал, татварын тайлан цалингийн цэсээс 5.8 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүлээ. Төсвийн хэмнэлтийн горимыг зөрчин 6.8 сая төгрөгийн тавилга, эд хогшил бэлтгэсэн, ЗДНХ-өөс 14.4 сая төгрөгийг уралдаан тэмцээний зардал, шагнал бусад зардал зарцуулсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын .. "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.4-д "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийн зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын .. "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүлээ.

Өмнөх жилийн зөрчлийг давтан гаргасан, СТА-ын 2021 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 01/102 дугаартай албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байгаа нь Төрийн албаны

тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Говь-Алтай аймгийн 2021 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 01/102 дугаартай албан шаардлагыг зөрчсөн.

Жилийн эцсийн тооллогоор 50.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө зөрүүтэй тоолсон, 86.4 сая төгрөгийн бараа материалыг тоолоогүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.", 67.2.-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна.", 73 дугаар зүйлийн 73.4-т "Үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ" СС-ийн 2000 онд баталсан Эд хариуцагчийн дүрмийг зөрчсөн.

4.4 Зөвлөмж

Илрүүлэлт: Шилэн дансанд мэдээлбэл зохих 200.9 сая төгрөгийн орлогын 43 гүйлгээнээс 170.7 сая төгрөгийн 8 гүйлгээг мэдээлээгүй.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1. Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ. 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалтыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шарга сумын ЗДТГ	19	219.9	6	9.9	2	0.6	10	209.1	1	
	Дүн	19	219.9	6	9.9	2	0.6	10	209.1	1	

